



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 550

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.4, 6.6 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Хархорин АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй 4,218,000.00 /дөрвөн сая хоёр зуун арван найман мянган/ төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Хархорин АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ж.Бадрах нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Акталсан хөрөнгийг худалдсанаас олох орлогыг /худалдахтай холбогдон гарсан зардлыг хассан дүнгээр/ компанийд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Акталж, данснаас хасаж сэлбэгээр худалдсан автомашины улсын дугаарыг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолт, дээрх арга хэмжээний биелэлтийн хамт 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


3.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001189

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн
570 дугаар тогтоолын хавсралт



“Хархорин АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн
хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах автомашин

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Сэлбэгээр худалдсанаас олох орлогын доод хэмжээ (төгрөг)
1	Кия бонго, 73-69 ӨВА, арал №651527	1993/ 2006	4,218,000.00	350,000.00
	Нийт дүн		4,218,000.00 /дөрвөн сая хоёр зуун арван найман мянга/	350,000.00 /гурван зуун тавин мянга/